

Сурагчийн биеэ авч явах дүрэм

Сурагч, эцэг эх, асран хамгаалагчид зориулсан мэдээлэл

NSW улсын сургуулиуд нь сургалтын бүхий л орчинд хүн бүрт аюулгүй, дэмжлэг үзүүлсэн, мөн сурагч бүрийн хэрэгцээг хангасан сургалтын орчинг бүрдүүлэхийг зорьдог. Бид сурагчиддаа хүртээмжтэй, аюулгүй байдлыг хангах зан үйлийг заан сургаж, үлгэр дууриалал үзүүлдэг.

NSW мужийн улсын сургуулийн сурагчид өөрийн бүхий л чадвараар биеэ дараах байдлаар авч явах ёстой:

- бусад сурагчид, сургуулийн багш ажилтнууд, ард иргэдэд хүндэтгэлтэй хандах
- сургуулийн болон ангийн дүрэм, мөн түүнчлэн багшийнхаа зааврыг дагаж мөрдөх
- суралцах явцад хамгийн өндөр стандартыг үргэлж эрэлхийлэх
- сургуулийн хамт олны бүх гишүүд үнэлэгдэж, хамрагдаж, дэмжигдсэн байхаар эелдэг, хүндэтгэлтэйгээр сурч биеэ авч явах
- зөрчилдөөнийг хүндэтгэлтэй, тайван, шударгаар шийдвэрлэх
- сургуулиас тогтоосон дүрэмт хувцасны талаарх журам болон хувцаслалтын дүрмийг дагаж мөрдөх
- өдөр бүр сургуульд ирж суралцах (хуульд өөрөөр заагаагүй л бол)
- бүх өмч хөрөнгөд хүндэтгэлтэй хандах
- аюулгүй байх, хүчирхийлэл үйлдэхгүй байх, мөн сургуульд зэвсэг, хууль бус мансууруулах бодис, архи, электрон тамхи, тамхи авчрахгүй байх.
- сургуулийн байр талбайд бусдыг дээрэлхэж, дарамталж, айлган сүрдүүлж, гадуурхахгүй байх

Өндөр чанартай сургалт, сургалтын үр дүнд хүрэхэд харшилсан, мөн өөрт болон бусдад хор хөнөөлтэй зан үйлийн хариуд сургууль арга хэмжээ авах болно.

Сурагч бүр дараах эрхийг эдэлнэ:

- сургуульд аюулгүй байдал хангагдсан байх
- суралцах орчин нь хүртээмжтэй байх, бүрэн оролцох боломжтой байх
- бусад сурагч, багш, сургуулийн ажилтнуудын зүгээс өөрт нь хүндэтгэлтэй хандах
- үзэл бодлоо илэрхийлэх, зорилго тавих, өөрийн эрхээ хамгаалах

Захирал болон сургуулийн ажилтнууд өөрсдийн мэргэжлийн дагуу сахилга батыг сахиулах ба аюулгүй, дэмжлэг үзүүлсэн, сурагч бүрийн хэрэгцээг хангасан сургалтын орчинг бүрдүүлнэ. Сурагчид эдгээр хүлээлтийг хангахгүй байх үед тэд зохих арга хэмжээг авч ажиллана.

Боловсролын яам нь хууль эрх зүйн бодлого журмыг боловсруулах, мэргэжлийн мэдээлэл баримтаар хангана. Захирал болон сургуулийн ажилтнуудыг нарийн мэргэжлийн зөвлөгөөгөөр хангаж, мэргэжлийн сургалтад хамруулах өөрийн ажил үүргээ гүйцэтгэхэд нь тусламж дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

Энэхүү хүрээнд NSW мужийн засгийн газар болон Боловсролын яам нь орон нутгийн түвшинд захирал, сургуулийн ажилтнуудын эрх мэдэл, тэдгээрийн гаргасан шийдвэрийг дэмжих болно.

Сурагчийн биеэ авч явах дүрэм: Сурагчийн үйлдэл

NSW мужийн улсын сургуулиудад бүхнийг хамруулсан, сурагчдын сурч боловсрох болон сайн сайхан байдал, аюулгүй байдлыг хангасан орчныг бүрдүүлэх нь Боловсролын Яамны нэн тэргүүний зорилт юм.

Хүндэтгэлтэй, аюулгүй, идэвхтэй суралцах орчныг бүрдүүлэх зорилго бүхий өндөр стандартад хүрэхийн тулд сургууль нь сурагчдад шаардлагатай сурч боловсрох орчныг бүрдүүлэхийг дэмжих зорилгоор төрөл бүрийн суралцах орчныг бүрдүүлэх юм.

Дээр дурдсан нөхцлийг хангахын тулд NSW мужийн улсын сургуулиудын сурагчид өөрсдийн бүхий л чадлаар дараах зарчмуудыг баримтлах ёстой.

Хүндлэл

- Бие биедээ хүндэтгэлтэй хандах.
- Бусадтай харилцах, эелдэг байх.
- Бусад сурагч, багш, сургуулийн ажилтнуудтай хамтран ажиллаж суралцах.
- Эерэг, хүндэтгэлтэй харилцааг хөгжүүлэх.
- Бусдын сонирхол, чадвар, соёлыг эрхэмлэн хүндэтгэх.
- Бусад сурагчийн сурах хэрэгцээг хүндэтгэх.
- Сургуулийн дүрэмт хувцсыг хувцаслалтын дүрмийн дагуу зохих ёсоор хувцаслах.
- Сургуулийн, багш ажилчид болон бусад сурагчдын өмч хөрөнгөнд хүндэтгэлтэй хандах.

Аюулгүй байдал

- Зан төлөв, биеэ авч явах дүрмийн талаарх сургууль, ангийн дүрмийг үлгэр жишээчээр дагаж мөрдөх.
- Харилцан ярилцаж, зөрчилдөөнийг эвээр шийдвэрлэх.
- Өөрийн зан байдал, үйлдэл нь бусдад хэрхэн нөлөөлж байгааг ойлгож өөрийн үйлдэлд хариуцлага хүлээх.
- Өөртөө болон бусдад санаа тавих.
- Аюулгүй байж, өөртөө болон бусдад хор хөнөөл учруулахгүй аюулгүй сонголт хийхэд нь бусдад туслах.

Хичээлийн оролцоо

- Сургууль, ангидаа цагтаа ирэх.
- Хичээл бүрт бэлтгэлтэй байх.
- Суралцах үйл явцад идэвхтэй оролцох.
- Сургалтын хамгийн өндөр стандартад хүрэхийн төлөө хичээн тэмүүлэх.

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрэв та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл сургуулийн захирал руу залгана уу. Танд орчуулагч хэрэгтэй бол Утсан орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаараар холбогдож өөрийн хэлээр орчуулагч авна уу.

Операторт залгахыг хүсч буй утасны дугаараа хэлвэл оператор шугаманд орчуулагчийг оруулж ирэн танд туслах болно. Энэхүү үйлчилгээ үнэ төлбөргүй.